МЕХАНИК ИНЖЕНЕРЧЛЭЛ МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР



ИНДЕКС: E071501

ЭЛСЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН: Бакалавр

СУРАЛЦАХ ХУГАЦАА: 1.5-2 жил

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО: Салбарын хөгжлийн чиг хандалга, техник, технологийн ашиглалт, зохион байгуулалт, зохион бүтээлт, түүний хөгжүүлэлт, зэргийг хариуцан ажиллах дадлага туршлагатай инженерийн болон эдийн засгийн шинжлэх ухааныг хослуулан хэрэглэн, үр ашгийг тооцож, төлөвлөх, удирдах бие даасан бүтээлч сэтгэлгээтэй, онолын болон судалгаа шинжилгээний орчин үеийн арга зүйн мэдлэг, чадвар, хандлагатай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц мэргэжилтэн, судлаачийг бэлтгэхэд оршино.

PLO 1 Техник технологийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны онол, арга зүйн мэдлэг эзэмших

PLO 2 Салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг судлах, шинжилгээ хийх, шийдвэр гаргах

PLO 3 Харилцааны ур чадвар болон гадаад хэлээр харилцах, ашиглах

PLO 4 Үйлдвэрлэлийн машин, технологийг хэрэглэх, удирдах, боловсронгуй болгох, хяналт тавих, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх

PLO 5 Машин тоног төхөөрөмжийн ажиллах чадвар, техникийн нөөцийг сэргээх, технологи ажиллагааг боловсруулах, техникийн системийг зохиомжлох, загварчлах, симуляци хийх, тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжлэх, дүгнэх

PLO 6 Механик системийн зохион байгуулалт, ажиллах зарчим, төхөөрөмж хэрэглэх, тэдгээрйг боловсронгуй болгох

PLO 7 Аливаа асуудлыг системтэй төлөвлөх, харьцуулах, тунгаан боловсруулах

PLO 8 Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйн тухай мэдлэг эзэмших, удирдах, багаар ажиллах, манлайлах

МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛҮҮД

- Шинжлэх ухааны онол ба судалгаа
- Тоон болон чанарын судалгаа
- Орчин цагийн менежментийн чиг хандлага
- Мэргэжлийн ёс зүй ба зөөлөн ур чадвар

МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛҮҮД

- Мехатроник системийн хэрэглээ
- Мэргэжлийн судалгаа, онолын семинар
- Магистрын дипломын ажил

ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ ЧАДВАР

- Инженерийн асуудлыг онолын болон тоон аргаар шинжлэх, загварчлах, шийдвэрлэх чадвар
- Туршилт, хэмжилтийн өгөгдлийг цуглуулах, боловсруулах, статистик болон инженерийн аргаар дүн шинжилгээ хийх чадвар
- Машин, механизм, системийн зохион бүтээлт, ажиллагааг инженерийн зарчимд тулгуурлан үнэлэх чадвар
- Инженерийн программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглах чадвар
- Олон улсын түвшинд мэргэжлийн харилцаа тогтоох, багаар ажиллах, инженерийн ёс зүйг баримтлах чадвар

СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛҮҮД

- Үйлдвэрлэлийн процессын автоматжуулалт
- Материалын эвдрэлийн онол
- Машины чичиргээ, дуу чимээ
- Машин механизмын синтез
- Зохион бүтээх арга зүй
- Машины оношилгоо, найдвартай ажиллагаа
- Триботехник
- Инноваци ба энтрепренершип
- Дотоод шаталтын хөдөлгүүрийн онол
- Хийцийн шинэ материал
- Тээврийн эдийн засаг II
- Материал боловсруулах дэвшилтэт технологи
- Хий ба шингэний машин
- Төслийн менежмент II*
- Инженерчлэлийн эдийн засаг II
- Динамик роботын загварчлал, удирдлага

МЭРГЭШҮҮЛЭХ ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, УР ЧАДВАР

- Орчин үеийн инженерийн программ хангамжийг ашиглан загварчлал, тооцоолол хийх
- Машин, механизмын ажиллагаанд инженерийн шинжилгээ хийж, оновчтой шийдвэр гаргах
- Системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийж, эрсдэлийг тодорхойлох
- Инженерийн салбарын тулгамдсан асуудлыг судалж, шинжилгээ хийж, шийдэл боловсруулах

АЖЛЫН БАЙР

- Механик инженер
- Төслийн инженер
- Үйлдвэрлэлийн инженер
- Засвар үйлчилгээ, ашиглалтын инженер
- Зохион бүтээх (дизайн) инженер
- Судлаач, багш